



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар

А/08

Мандалговь

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г, Газрын дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай томилсугай. Үүнд:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц, дотоод хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Дэл уул, Цагаан суварга орчмын байгаль хамгаалагч

Ерөнхий нягтлан бодогч

2. Ёс зүйн дэд хорооны анхдугаар хуралдааныг 2024 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулж Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга тус тус сонгосугай.

3. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль, дүрэм, журам холбогдох бичиг баримтын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ГАНТУЛГА

Tuhsaal A.docx

482401023